



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/551

Эрдэнэт

Сургалтын материаллаг баазыг сайжруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6.а, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Дайчилгааны тухай хуулийн 28,29 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Батлан хамгаалахын сайд Орхон аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээ, Цэргийн сургалт бэлтгэлийн 2017 оны үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын танхимыг шинэчилж засварлах, сургалтын материаллаг баазыг сайжруулах ажлуудыг өөрсдийн хүчээр зохион байгуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Г.Батсуурьт даалгасугай.

Хоёр. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын танхимыг шинэчилж засварлах, сургалтын материаллаг баазыг сайжруулахад шаардагдах 5 сая төгрөгний төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын танхимыг шинэчилж засварлах, сургалтын материаллаг баазыг сайжруулахад шаардагдах 5000000 /Таван сая / төгрөгийг аймгийн 2016 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын материаллаг баазыг сайжруулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 7-дугаар сарын 24-ны өдрийн 48-дугаар захирамжийн хавсралт

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэхэд шаардагдах төсвийн тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Хоол, цай ундааны зардал					
1.	Хоол /2017 оны 07 дүгээр сарын 25-30-ний өдрүүдэд/	6	5 өдөр	6000	180000
Бүгд					180000

Сургалтын материаллаг баазыг сайжруулахад шаардагдах төсвийн тооцоо

№	Материал хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	100	ширхэг	20000	2000000
2	Сургалтын самбар /140 см x 100см/	8	ширхэг	62500	500000
Бүгд					2500000
Сургалтын танхимыг шинэчилж засварлахад шаардагдах төсвийн тооцоо					
1	Вакуум хаалт	3,4	м2	121300	412420
2	Вакуум хаалга	1,6	м2	199900	319840
3	Вакуум цонхны шил	1,7	м2	37600	63900
4	Танхимын гэрэл /суурьтай/	6	ком	80000	400000
5	Цахилгааны засварын материал хэрэгсэл				150000
6	Сантехникийн засварын материал хэрэгсэл				300000
7	Шалны хулдаас LJ	50	м2	10000	500000
8	Барилгын засварын материал хэрэгсэл				173840
Бүгд					2320000
Нийт					5000000